



НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/27

Улаанбаатар хот

“Улаанбаатар марафон-2017” олон улсын
гүйлтийн шүүгч, зохион байгуулагч
бэлтгэх сургалт-семинар явуулах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 144 дүгээр зарлиг, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/147 дугаар захирамж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Улаанбаатар марафон-2017” олон улсын гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх сургалт, семинарыг 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгуулсугай.

2. Сургалт-семинарыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт-семинарт шаардагдах 569.000 /таван зуун жаран есөн мянган/ төгрөгийг Нийтийн биеийн тамир, спортын хорооны сургалт, семинарын зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй..

4. Сургалт-семинарыг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга /А.Болдмаад/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500073

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны даргын 2017 оны 05 дугаар сарын 09 ны өдрийн 11 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Марафон гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх сэдэвт сургалт-семинарын төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багшийн ажлын мөнгө 1/хоног/ х 8 цаг х 20.000/төг/	160.000
2.	Заал, талбайн хөлс	100.000
3.	Бичиг хэргийн зардал	109.000
4.	Сертификат хэвлүүлэх	100.000
6.	Видео бичлэг, зураг, хальс анонс	100.000
ДҮН:		569.000

Боловсруулсан:

Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга

А.Болдмаа

Хянасан:

Нягтлан бодогч

О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны
даргын 2017 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн
А/27 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Марафон гүйлтийн шүүгч, зохион байгуулагч бэлтгэх
сургалт семинарын хичээл заах багш нарын бүрэлдэхүүн

- | | |
|------------------|--------------------------------------|
| 1. А.Болдмаа | НБТСХ-ны хэлтсийн дарга |
| 2. Д.Баярлах | МУБИС-ийн УБТС-ийн тэнхимийн эрхлэгч |
| 3. Н.Уранчимэг | Улсын шүүгч |
| 4. Г.Батцэцэг | Улсын шүүгч |
| 5. С.Өнөрбаатар | Улсын шүүгч |
| 6. Б.Энхбаатар | ҮБТДС-ийн багш магистр-Улсын шүүгч |
| 7. Ганбат | Улсын шүүгч |
| 8. Э.Мөнх-Эрдэнэ | Шүүгч |